



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-10-75, Факс: 32-70-16
E-mail: fiscalcouncil@parliament.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Р.СЭДДОРЖ ТАНАА

2026.03.25 № 19
танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.5.3-д заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн дүгнэлтийг хүргүүлж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.5.3 “Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах”-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх чиг үүргийг хэрэгжүүлдэг болно.

Энэ хүрээнд “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайлан, бусад холбогдох материалуудыг судалж, төлөвлөлтийн бодлого, хэрэгжилт, төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн зарцуулалт, бодлогын уялдаа холбоо, хэрэгжилтийн үр дүнд шинжилгээ хийж, холбогдох дүгнэлтийг боловсрууллаа.

Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө нь хангалтгүй байгаа бөгөөд энэ нь хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлтийн уялдаа, бодлогын чиглэл, тогтвортой байдал, төсөл, арга хэмжээний сонголт, гүйцэтгэлийн чанар, хяналт, санхүүжилт зэрэг олон талт хүчин зүйлсээс хамаарч байгааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл онцолж хөгжлийн төлөвлөлт, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөмжүүдийг дүгнэлтэд тусгасан болно.

Хавсралт 17 хуудастай.

Хүндэтгэсэн,

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ДЭЛГЭРСАЙХАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Ц.САНДАГ-ОЧИР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-10-75, Факс: 32-70-16
E-mail: fiscalcouncil@parliament.mn

2026.03.25 № 18

танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.5.3-д заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн дүгнэлтийг хүргүүлж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.5.3 “Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах”-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх чиг үүргийг хэрэгжүүлдэг болно.

Энэ хүрээнд “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайлан, бусад холбогдох материалуудыг судалж, төлөвлөлтийн бодлого, хэрэгжилт, төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн зарцуулалт, бодлогын уялдаа холбоо, хэрэгжилтийн үр дүнд шинжилгээ хийж, холбогдох дүгнэлтийг боловсрууллаа.

Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө нь хангалтгүй байгаа бөгөөд энэ нь хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлтийн уялдаа, бодлогын чиглэл, тогтвортой байдал, төсөл, арга хэмжээний сонголт, гүйцэтгэлийн чанар, хяналт, санхүүжилт зэрэг олон талт хүчин зүйлсээс хамаарч байгааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл онцолж хөгжлийн төлөвлөлт, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөмжүүдийг дүгнэлтэд тусгасан болно.

Хавсралт 18- хуудастай.

Хүндэтгэсэн,

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ДЭЛГЭРСАЙХАН



**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН”-Д ӨГСӨН ТӨСВИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

АГУУЛГА

Оршил	3
Нэг. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтийн талаар	4
1.1. Хөгжлийн бодлогын хэрэгжилт	4
1.2. Хөгжлийн бодлогын тогтвортой байдал, хэмжүүр	6
1.3. Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд өгөх дүгнэлт	8
Хоёр. Дүгнэлт, зөвлөмж	11
2.1. Жилийн хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаарх дүгнэлт	11
2.2. Жилийн хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг сайжруулах талаарх зөвлөмж	13
2.3. Хууль эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой санал	14
ХАВСРАЛТ	15

Зургийн жагсаалт

Зураг 1.Хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл /2023-2025/	6
Зураг 2.Хөгжлийн тэргүүлэх зорилтууд, хэмжүүр	8

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл ба макро эдийн засгийн зарим үзүүлэлтийн харьцуулалт	5
Хүснэгт 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн байдал	5
Хүснэгт 3.Монгол Улсын 2024, 2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн харьцуулалт	7
Хүснэгт 4. Хөгжлийн төлөвлөгөөний хөтөлбөрийн үр дүн	8
Хүснэгт 5.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн	9
Хүснэгт 6.Санхүүжилтийн гүйцэтгэл /Төсөл, арга хэмжээний тоо/	9
Хүснэгт 7.Санхүүжилтийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/	10

Оршил

Монгол Улсын Засгийн газраас Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалтын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”-г холбогдох материалын хамт УИХ-д өргөн мэдүүлж, ЗГХЭГ-аас Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд 2025 оны 3 дугаар сарын 09-ний өдөр ХЭГ/754 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

УИХ-ын 2024 оны 35 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийг тус тус баталсан бол Засгийн газрын байгууллагууд уг төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж тайлагнасан байна. Гэвч ЗГХЭГ-аас ирүүлсэн албан бичиг нь “Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”-г хүргүүлээ гэсэн агуулгатай байсан боловч нийт 20 хуудас бүхий “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан” байсныг дурдах шаардлагатай.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”-тай танилцан, шинжилгээ хийж, “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн 16¹.5.3 дахь заалтад “Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах” гэж заасны дагуу дараах дүгнэлтийг хүргүүлж байна.

Бид ЗГХЭГ-аас ирүүлсэн мэдээлэл болон батлагдсан хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, Зөвлөлөөс Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд өгсөн дүгнэлт, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн Төрийн аудитын байгууллагын нийцлийн аудитын тайлан, Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланд хийсэн дүн шинжилгээний тайлан” зэргийг ашиглаж, 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан “Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”, түүний дагалдах баримтууд, өргөн барьсан хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн баримт бичигт үндэслэн, хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг үнэлж, холбогдох санал, дүгнэлт өгсөн болно.

Нэг. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтийн талаар

Сүүлийн жилүүдэд хөгжлийн бодлого төлөвлөлтийн эрх зүйн орчин, төлөвлөлтийн баримт бичиг, тэргүүлэх чиглэл, зорилтууд харьцангуй сайжирч байгааг ТТБЗ-ийн зүгээс онцлохын сацуу хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой шийдвэрлэвэл зохих нэлээд асуудал байгааг жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд ТТБЗ, УАГ, УИХ-ын Тамгын газраас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангуудад тусгагдсан дүгнэлт харуулж байгааг тэмдэглэе.

Мөн Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зорилтод түвшин, хүрэх үр дүн харьцангуй тодорхой болж байгаа нь хэрэгжилтэд эерэг нөлөөлж болох нэг хүчин зүйл юм.

Гэвч хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой шийдвэрлэвэл зохих асуудлууд байгааг жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд ТТБЗ, УАГ, УИХ-ын Тамгын газраас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангуудад тусгагдсан дүгнэлт гэрчилж байна. Иймд ТТБЗ өөрийн хийсэн шинжилгээндээ үндэслэсэн дараах чиглэлээр дүгнэлтээ гаргалаа.

1.1.Хөгжлийн бодлогын хэрэгжилт

Хөгжлийн төлөвлөгөөний нийгэм-эдийн засгийн үр нөлөөг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд а) Эдийн засгийн бодлого, б) Бүсчилсэн хөгжлийн бодлого, в) Хүний хөгжлийн бодлого, г) Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн бодлогын үндсэн 4 тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, түүний хүрээнд дэд бодлогын зорилтыг дэвшүүлжээ.

“Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд тодорхойлсон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр улсын эдийн засаг 2025 онд 8 хувиар өсөж, экспорт 19.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад валютын улсын нөөц нэмэгдэж, инфляц зорилтот түвшинд хадгалагдаж, ядуурал буурч, хүний хөгжлийн индекс, засаглалын индексийн үзүүлэлт сайжирна” (УИХ, 2024) хэмээн хөгжлийн бодлогын үр дүнг тодорхойлсон байна. Үүнээс гадна нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2 хувийн ашигтай байх зорилт тавьсан.

Засгийн газраас ирүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-д эдгээр үзүүлэлтийн үр дүн буюу хөгжлийн төлөвлөгөөний нэгдсэн үр дүнг тусгайлан тусгаагүй байна. Харин уг тайлангийн 1 дүгээр хавсралтад бодлогын тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэлийг тодорхой үзүүлэлтүүдээр хэмжихийг зорьсон нь оновчтой эсэхийг анхаарах шаардлагатай.

Бидний зүгээс хөгжлийн бодлогын үр дүнг бодитой харах зорилгоор дээрх болон бусад үзүүлэлтийн төлөвлөлт гүйцэтгэл, суурь болон тайлант оны нөхцөл байдлыг харьцуулан дүгнэв.

Ингэхдээ 2024 онд Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилгот түвшний (УИХ, 2024) зарим үзүүлэлтэд үндэслэсэн болно.

Хүснэгт 1. Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл ба макро эдийн засгийн зарим үзүүлэлтийн харьцуулалт

д/д	Үзүүлэлт	2024 он	2025 он	
			Зорилт	Гүйцэтгэл
1	Эдийн засгийн өсөлт (хувь)	6	8 хувь 6-аас дээш хувьд хадгална.*	6.8 (урьдчилсан гүйцэтгэл)
2	Экспорт (сая ам.доллар)	15,783.38	19,000.0	15,701.47
3	Гадаад валютын нөөц	5,509.82	нэмэгдүүлэх	7,005.28
4	Инфляц	8.3	7 хувь*	7.5
5	Хүний хөгжлийн индекс	104-р байр (2023 он)	95-р байр	-
6	Ядуурлын түвшин	27.1	25 хувь*	-
7	Эдийн засгийн эрх чөлөөний индекс	76/176	75	74
8	Төсвийн алдагдал (тэрбум төгрөг)	-920.2	-1,365.2	-1,231.5

**Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны зорилт*

Жич: Хүснэгт дэх мэдээлэлд ҮСХ, Монголбанк, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Сангийн яамны эх сурвалжийг ашиглав.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний зарим зорилт биелсэн боловч эдийн засгийн өсөлт, гадаад худалдаа зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүд зорилтот түвшинд хүрч хэрэгжээгүй, ядуурал, хүний хөгжил зэрэг нийгмийн үзүүлэлтүүдийн хувьд бодитой өөрчлөлт гарсан эсэх нь тодорхойгүй байгааг анхаарах шаардлагатай.

Эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 6.8 хувьтай гарахад ХАА-н салбар, түүний дотор мал аж ахуйн салбарын өсөлт голлон нөлөөлсөн нь цаашид өсөлт өндөр гарах боломжтой эсэх, хөгжлийн бодлогын нийгэм, эдийн засгийн нөлөөлөл ямар байгааг тодруулах шаардлагыг бий болгож байна. Иймээс хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ макро эдийн засгийн болон нийгмийн ямар үзүүлэлтэд хэрхэн нөлөөлсөн болохыг, тодруулбал, хөгжлийн бодлого макро эдийн засгийн ямар зорилтод чиглэснийг тодорхойлж, жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд нарийвчлан тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бодлогын хэрэгжилт эдийн засаг, нийгмийн ямар эерэг өөрчлөлтийг бий болгож чадсаныг тодорхойлох аргачлал, хэмжүүрийг бий болгох шаардлагатай байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Монгол Улсын хөгжлийн бодлогын тухайд онцгойлон анхаарч ач холбогдол өгч байх гол зүйл бол түүний хэрэгжилтийн асуудал юм. Жил бүр хөгжлийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж байгаа хэдий ч гүйцэтгэлийн хувь ямагт хангалтгүй байсаар ирсэн бөгөөд улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийг (ТЕЗ-ийн үр дүнгээр) Засгийн газар 59.7 хувь, ҮАГ 63.7 хувь гэж үнэлсэн нь нэг бол биелэгдэх боломжгүй зорилтууд дэвшүүлдэг эсвэл аль ч шатанд ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.


Хүснэгт 2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн байдал

д/д	Үзүүлэлтүүд	ЗГХЭГ	ҮАГ	Дундаж
1	Бодлогын үр дүн	48.5	20.9	34,7
2	ТЕЗ-ийн үр дүн	59.7	63.7	61.7
3	Хөтөлбөрийн үр дүн	57.1	62.0	59.55
4	ТАХ-ний хэрэгжилт	61.0	58.1	59.55

Эх сурвалж: (МУЗГ, 2026)

Хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ ихээхэн доогуур, нарийвчлан харвал олон ажил огт хийгдээгүй байгаа нь хөгжлийн төлөвлөгөөг бид бодитой баталж чадахгүй байгааг гэрчилж байгаа хэрэг юм.

Зураг 1.Хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл /2023-2025/



Эх сурвалж: МУЗГ, 2026

Зурагт 2023, 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний ерөнхий гүйцэтгэлийн түвшинг 2025 оны хөгжлийн тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэлийн түвшинтэй харьцуулан харууллаа. 2025 оны хувьд хөгжлийн тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл доогуур байгаа ч төсөл, арга хэмжээ 61.0 хувь, хөтөлбөрийн үр дүн 57.1 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчдын үр дүн 59.7 хувь байна. Энэ нь 2025 онд хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл тодорхой хэсгүүдэд сайжирсан ч гол зорилтууд хангалттай хэрэгжээгүй гэсэн үг юм.

Сүүлийн 3 жилийн байдлаар улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт тогтвортой бус, 2024 онд огцом буурч 2025 онд зарим чиглэлд өссөн байдалтай байна. Иймд хөгжлийн төлөвлөлтийг бодит хэрэгжилтийн чадавх, санхүүжилтийн баталгаатай уялдуулах, мөн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулж, гүйцэтгэлийг тогтвортой нэмэгдүүлэх шаардлагатай.

1.2.Хөгжлийн бодлогын тогтвортой байдал, хэмжүүр

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой байдлыг хадгалах шаардлагатай. Монгол Улсын Үндсэн Хуулийн 25 дугаар зүйлийн 1.7-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” хэмээн заасан. Гэвч УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр гурван намаас бүрдсэн Засгийн газар үйл ажиллагаагаа явуулж хөгжлийн бодлогын зорилт, чиглэлийг хэт өөрчилж эхэлсэн нь бодлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн.

Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд хөгжлийн 4 тэргүүлэх чиглэлийг, харин 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тэргүүлэх 8 чиглэлийг тодорхойлсон байжээ. 2024, 2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг харьцуулан дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 3.Монгол Улсын 2024, 2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн харьцуулалт

д/д	2024 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх зорилтууд	2025 оны хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх зорилтууд
1	Экспортыг нэмэгдүүлнэ	Эдийн засгийн бодлого
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	Бүсчилсэн хөгжлийн бодлого
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна	Хүний хөгжлийн бодлого
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна	
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна	
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна	
8	Ногоон хөгжлийг дэмжинэ	

Эх сурвалж: (УИХ, 2023) (УИХ, 2024)

Монгол Улсын 2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хувьд эдийн засаг, нийгмийн гол асуудлууд руу чиглэсэн, урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдаатай байдал нэмэгдсэн эерэг тал байна. Харин 2024 оны хөгжлийн тэргүүлэх зорилтууд нь хөгжлийн зорилт гэхээсээ тодорхой асуудлыг шийдэхэд –чиглэсэн хандлагатай байв. Нөгөө талаас 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тэргүүлэх чиглэлийн үр дүнг нарийвчлан тодорхойлоогүй бол 2024 онд тэргүүлэх чиглэлийн үр дүнг чиглэл тус бүрээр нарийвчлан тодорхойлж зорилтот түвшин, хариуцах эзнийг зааж өгсөн нь давуу талтай байсан (Хавсралт 1-ээс 2024 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, хүрэх үр дүнтэй танилцана уу).

2025 оны хувьд тэргүүлэх чиглэл нь сайжирсан ч тэдгээрийн хэрэгжилтийг хэрхэн үнэлэх, хэрхэн хэмжих, үр дүнг хэрхэн тодорхойлох асуудлыг тодорхой тусгаагүй нь үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 1 дүгээр хавсралт"-д тусгасан хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг үнэлсэн байдлаар тодорхой харагдаж байна. (Хавсралт 1-оос. Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын тэргүүлэх чиглэлийн үнэлгээтэй дэлгэрэнгүй танилцана уу.)

Доорх зургаас хоёр гурван гол зүйлийг онцлох шаардлагатай. *Нэгдүгээрт*, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг үнэлэх хэмжүүр нь тухайн асуудлыг иж бүрнээр тодорхойлж чадаж байгаа эсэх асуудал, *хоёрдугаарт*, оноосон хэмжүүр нь оновчтой эсэх асуудал болно. Энд эдийн засгийн бодлогыг эдийн засгийн өсөлтөөр хэмжих нь гарцаагүй мэт боловч өсөлтөд хөгжлийн бодлогын нөлөөлөл хэр байсныг тодорхойлохгүйгээр асуудлын мөн чанарыг бодитой харах боломж хязгаарлагдмал юм.

Ялангуяа 2025 оны эдийн засгийн өсөлтийн бүтэц, түүнчлэн энэхүү өсөлт тогтвортой бус, тодорхой салбарын нөлөөлөл ихээхэн өндөр байгааг цаашид харгалзан үзвэл зохино. Мөн хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогод хүний эрх, бизнесийн эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний индексийг оруулах шаардлагатай байж болох зэрэг олон асуудал бодлогын хэмжүүрт харагдаж байна. *Гуравдугаарт*, хөгжлийн бодлогод олон дэд зорилт дэвшүүлэн хөтөлбөр арга хэмжээ бүрд хүрэх үр дүнг тодорхойлж тэдгээрийг нэгтгэх байдлаар хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж байгааг анхаарах шаардлагатай. Үүнтэй холбоотой хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл харилцан адилгүй гарч болох бөгөөд тэргүүлэх зорилго

хангагдаагүй байхад дэд зорилтын биелэлт өндөр гарах боломжгүйг анхаарч хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдах хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тэргүүлэх зорилгод хандуулах нь зүйтэй байна.

Зураг 2.Хөгжлийн тэргүүлэх зорилтууд, хэмжүүр



Эх сурвалж: (МУЗГ, 2026)

Хөгжлийн төлөвлөгөөний бодлого, хэрэгжилт, хэмжүүрийг шинжлэхэд хэрэгжилт хангалтгүй байгаагийн шалтгаан нь бодлогын тогтворгүй байдал, тэргүүлэх болон дэд зорилтын оновчгүй байдал, хэмжүүр тодорхойгүй, оновчтой бус байгаа зэрэг хүчин зүйлс гэж үзэж болохоор байна.

1.3.Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд өгөх дүгнэлт

Монгол улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлсэн чиглэлүүдийн үнэлгээ хийсэн байдалд суурилан дараах дүгнэлтүүдийг өгч байна.

Хөтөлбөрийн үр дүн

Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн тайланд дараах байдлаар хөгжлийн бодлогын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэн байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт нь хүний хөгжлийн бодлого 64.1 хувьтай хамгийн өндөр, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого 58.8 хувь, эдийн засгийн бодлого 57.3 хувьтай хангалтгүй түвшинд байна. Харин бүсчилсэн хөгжлийн бодлого 35.3 хувьтай хамгийн бага үзүүлэлттэй байгаа нь бодлогын чиглэл тус бүрд хэрэгжилтийн түвшинд 28.8 пунктын зөрүү байгааг харуулж байна. Энэ нь бодлого хэрэгжихдээ салбар хооронд жигд бус, ялангуяа бүсийн хөгжлийг дэмжих зорилт бодитоор хангалтгүй хэрэгжиж байгааг илтгэнэ.

Хүснэгт 4. Хөгжлийн төлөвлөгөөний хөтөлбөрийн үр дүн

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
Эдийн засгийн бодлого	хувь	57.3
Бүсчилсэн хөгжлийн бодлого	хувь	35.3
Хүний хөгжлийн бодлого	хувь	64.1
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	хувь	58.8
Нийт	хувь	57.1

Ийм зөрүү үүссэн нь нөөцийн хуваарилалт, санхүүжилт, хэрэгжилтийн зохион байгуулалт харилцан адилгүй байгаатай холбоотой бөгөөд цаашид гүйцэтгэл доогуур хувьтай байгаа чиглэлд бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ 57.1 хувьтай байгаа нь хөгжлийн бодлогын хэрэгжилт хангалтгүй түвшинд байгааг илэрхийлж байна. Энэ нь бодлогын зорилтууд тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа боловч зорилтот түвшинд хүрээгүй, хэрэгжилтийн чанар хангалтгүй байгааг харуулна. Түүнчлэн хөтөлбөрийн үр дүнгийн энэ түвшин нь төсөл, арга хэмжээний 61.0 хувийн хэрэгжилтээс бага байгаа нь бодлогын зорилтуудыг хөтөлбөрийн түвшинд бүрэн нэгтгэж, үр дүн болгон хэрэгжүүлэх, үнэлэхэд хүндрэл учирч буйг илтгэж байна. Иймд хөтөлбөрүүдийг илүү үр дүнд чиглэсэн, хэрэгжилтийн уялдаа сайтай байдлаар төлөвлөх шаардлагатай юм.

Төсөл, арга хэмжээний үр дүн

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт 61.0 хувьтай гарсан байгаа нь хөтөлбөрийн түвшнээс өндөр боловч чанарын хувьд хангалтгүй байна. Нийт 326 төслөөс 161 буюу 49.1 хувь нь зорилтот түвшинд хүрч хэрэгжсэн бол 165 буюу 50.9 хувь нь хангалтгүй гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 5.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
Төсөл, арга хэмжээний тоо	тоо	326
Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ	хувь	61.0
≥85% гүйцэтгэлтэй	тоо	161
	хувь	49.1
<85% гүйцэтгэлтэй	тоо	165
	хувь	50.9

Энэ нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийн гүйцэтгэлийн чанар, үр дүн хангалтгүй байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, төсөл, арга хэмжээний тал орчим хувь нь зорилтот түвшинд хүрээгүй байгаа нь төлөвлөлт, бэлтгэл, хэрэгжилтийн удирдлага сул байгааг харуулж байна. Иймд төслийн сонголт, эрэмбэлэлт, хэрэгжилтийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл

Нийт 326 төслөөс 287 буюу 88.0 хувь нь санхүүгийн эх үүсвэртэй төлөвлөгдсөн боловч үүнээс зөвхөн 180 буюу 62.7 хувь нь бодитоор санхүүжигдсэн байна.

Хүснэгт 6.Санхүүжилтийн гүйцэтгэл /Төсөл, арга хэмжээний тоо/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
Төсөл, арга хэмжээний нийт тоо	тоо	326
Эх үүсвэртэй төсөл	тоо	287
	хувь	88.0
Санхүүжилт авсан төсөл	тоо	180
	хувь	62.7

Энэ нь нийт төслөөс 146 төсөл санхүүжилтэд бүрэн хамрагдаагүй, мөн төлөвлөгдсөн санхүүжилтийг бүрэн олгоогүйг харуулж байна. Төлөвлөлтөд багтсан төслийн 37.3 хувь нь

санхүүжилтгүй байгаа нь төлөвлөлт бодит төсвийн чадавхтай нийцээгүй, “хэт өргөтгөсөн төлөвлөлт” хийж байгааг илтгэнэ.

Хүснэгт 7. Санхүүжилтийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
Төлөвлөсөн төсөв	сая төгрөг	9,259,359.3
Гүйцэтгэл	сая төгрөг	5,443,915.4
Гүйцэтгэлийн хувь	хувь	58.8
Санхүүжилт авсан төсөл	тоо	180

Нийт санхүүжилтэд 9.26 их наяд төгрөг төлөвлөснөөс 180 төсөлд 5.44 их наяд төгрөгийг зарцуулж, 58.8 хувьтай хэрэгжсэн байна. Төлөвлөгдсөн санхүүжилт бүрэн олгогдоогүй байгаа нь төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн авч үзэхэд хөтөлбөрийн хэрэгжилт 57.1 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 58.8 хувь байгаа нь хөгжлийн бодлого болон төсвийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байгааг харуулж байна. Нийт 326 төслөөс 287 буюу 88.0 хувь нь эх үүсвэртэй төлөвлөгдсөн боловч зөвхөн 180 буюу 62.7 хувь нь бодитоор санхүүжилт авсан нь төлөвлөлт болон хэрэгжилтийн хооронд зөрүү байгааг илтгэж байна.

Иймд хөгжлийн төлөвлөлт, төслийн сонголтыг сайжруулах, санхүүжилтийг бодитой төлөвлөж уялдааг хангах нь хэрэгжилтийг сайжруулах суурь нөхцөл гэдгийг анхаарах шаардлагатай. Түүнчлэн хэрэгжилт хангагдах нөхцөлийг бүрдүүлэх, хяналтыг сайжруулах, мөн төсвийн хөрөнгийн зарцуулалтыг үр дүнд суурилсан байдлаар оновчтой болгох шаардлагатай гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэж байна.

Өнгөрсөн онуудын жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах явцад хэт өөдрөг олон үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөдөг боловч бодит байдал дээр хэрэгжилт нь тааруу байсан талаар жил бүрийн Үндэсний Аудитын Газраас гаргасан аудитын дүгнэлтэд тусгасан байдаг. Гэвч өнөөг хүртэл дээрх алдаа дутагдал төдийлөн засагдаагүй үргэлжилсэн хэвээр байна.

Бид хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа салбар бүрд олон тооны зорилтыг хэрэгжүүлнэ гэж төлөвлөдөг боловч бодит байдал дээр түүний хэрэгжилт тааруу хэвээр байна. Ийнхүү хэрэгжилт тааруу гарахад нөлөөлж байгаа гол хүчин зүйлсийг дор дурдсанаар тайлбарлаж болохоор байна.

- Төлөвлөгөөг судалгаа шинжилгээний үндсэн дээр бус хэт хийсвэр байдлаар боловсруулдаг.
- Аливаа төсөл, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхийн өмнө бэлтгэл ажлыг бүрэн хангадаггүй.
- Төлөвлөгөөг боловсруулахдаа хөрөнгийн эх үүсвэрийн хүрэлцээтэй байдалтай уялдуулан зөв тооцож, төлөвлөж чаддаггүй.
- Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тавих хяналт шалгалт тааруу буюу маш сул.
- Алслагдсан сум, суурин газарт хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, их засварын ажил үндсэндээ ямар ч хяналтгүйгээр хэрэгждэг.
- Зөвхөн болж өнгөрсөн, хэрэгжүүлсэн үйл явцын араас хяналт шинжилгээ хийх байдлаар явж ирсэнтэй холбоотой байна.

Хоёр. Дүгнэлт, зөвлөмж

2.1. Жилийн хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаарх дүгнэлт

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дээрх шинжилгээ, харьцуулалт болон бусад судалгаанд үндэслэн дараах дүгнэлтүүдийг өгч байна. Үүнд:

Хөгжлийн бодлогын тогтвортой байдал хангагдахгүй байна. Монгол Улсын хөгжлийн бодлогын тэргүүлэх, дэд зорилтууд нь урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэж, хөгжлийн бодлого тогтвортой байх нь үр дүнд хүрэх боломжийг нэмэгдүүлнэ гэдгийг анхаарах шаардлагатай. Зөвхөн 2024, 2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх зорилтуудыг харьцуулахад хэт өөрчлөлттэй тогтвортой бус байгаа нь харагдаж байна. Цаашид хөгжлийн тэргүүлэх чиглэлийг баримталсан жилийн хөгжлийн бодлогын тогтвортой зорилтуудын дэвшүүлж ажиллах шаардлагатай байна.

Хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг урт хугацааны хөгжлийн бодлогод нийцтэй, бодитой тодорхойлох, хэмжигдэхүйц байдал дутагдалтай. Хөгжлийн тэргүүлэх зорилтууд, түүний хэмжүүр нь оновчтой бус байгаа нь хөгжлийн бодлогын үр нөлөөг бодитой тодорхойлох боломжийг хязгаарлаж байна. Ялангуяа тэргүүлэх зорилтуудыг оновчтой тодорхойлж түүнийг бодитой хэмжих, дэд зорилтуудыг тэргүүлэх зорилтуудад чиглүүлэх шаардлагатай. Чухамдаа хөгжлийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн нь эдийн засаг, нийгэмд ямар эерэг нөлөө авчирсан, алдаа дутагдал нь юу байсныг харах боломж хязгаарлагдмал байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдэж байгаа нь хөгжлийн бодлого төлөвлөлт ба төсөвлөлтийг уялдуулаагүйгээс шалтгаалсан байна. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 53.7 хувийг улсын жилийн төсөвт тусгаагүй байна. Улсын төсвөөс санхүүжих нийт 160 төсөл, арга хэмжээнээс 74 төсөл, арга хэмжээ буюу 46.3 хувь нь Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд тусгагдан, 86 төсөл, арга хэмжээ буюу 53.7 хувийг нь хэрэгжүүлэх санхүүжилт батлагдаагүй байна. Энэ нь Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн оны батлагдсан төсөв хоёрын хооронд уялдаа холбоо сул, “жилийн төсөв нь тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд суурилсан байх” гэсэн зарчмыг баримтлаагүйг илтгэнэ.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж батлахдаа гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн суурь болон хүрэх түвшнийг зохистой тодорхойлоогүй нь хэрэгжилтийг үнэлэх боломжгүй болгож байна. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг бэлтгэхдээ бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, бодлогын үндэслэлд нийцүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, үр дүнгийн суурь болон зорилтот түвшнийг гаргахыг хичээсэн ч төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн нь SMART буюу хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц байх шаардлагыг хангаагүй, зарим шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй, тухайлбал, “арга хэмжээний хэрэгжилт”, “барилгын ажлын гүйцэтгэл”, “төслийн хэрэгжилт” гэх мэтээр хэт ерөнхий тодорхойлсон, хэд хэдэн үзүүлэлтийн суурь түвшин байхгүй боловч зорилтот түвшин нь бүгд 100 хувь гэх мэтээр баталсан нь жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитойгоор үнэлэх боломжгүй болгосон байна.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсвийг боловсруулж, хэлэлцэн батлахдаа зарцуулахаар тооцсон зардлыг бүрэн санхүүжүүлээгүй байгаа нь тодорхой харагдаж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төслүүдийн хэрэгжих боломж нь санхүүжилтийн эх үүсвэрээс шууд хамааралтай байдаг. Гэтэл Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд 19.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 373 шалгуур үзүүлэлт бүхий 328 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган баталжээ. Эдгээр төсөл, арга хэмжээг 2025 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 5.3 их наяд, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 4.2 их наяд, төр хувийн хэвшлийн хөрөнгөөр 4.5 их наяд, гадаад, дотоод хөрөнгө оруулалтаар 4.2 их наяд, бусад эх үүсвэрээс 1.3 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцсон бол нийт зарцуулах төсвийн 37.9 хувийг л ондоо багтааж санхүүжүүлсэн нь жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна. Ийнхүү хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа нь төсвийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээ улсын төсөвт бүрэн тусгаагүй, 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр санхүүжилт хасагдсан, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч нь тодорхойгүй зэргээс шалтгаалжээ.

Энэ нь “Бодит байдалд экспортын болон төсвийн гүйцэтгэл төсөөлж буй хэмжээнээс буурах, төсвийн орлого тасалдах, улмаар улсын төсвийн алдагдал нэмэгдэх, 2025 оны улсын хөгжлийн болон төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан ч орлого, санхүүжилтийн тасалдлын улмаас хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт зогсох, он дамжих хөрөнгө оруулалт, барилга объектын тоо нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэх магадлал өндөр байна. Иймд Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг бүхэлд нь хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал гэж үзэж болохоор байна” гэж ТТБЗ-өөс өмнө нь өгч байсан дүгнэлт бодит байдалд биелснийг харуулж буй юм.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан нь төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн байна. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэлийг нь гаргах шаардлагатай байсан 102 төсөл, арга хэмжээнээс ТЭЗҮ нь батлагдаагүй 22 төсөл, арга хэмжээ байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу санхүүжилтийн эх үүсвэрийг нь тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан төсөл, арга хэмжээг жилийн төлөвлөгөөнд тусгасан байх шаардлагыг зөрчсөн байна. Ийм техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээ нь ихэвчлэн улс төрийн лобби, захиалгатайгаар жагсаалтад нэмж орсон төслүүд байх нь элбэг бөгөөд эдгээр төслийн гүйцэтгэлийн чанар хангалтгүй, анх төлөвлөсөн төсөвт өртгөөс хэтэрч төсөл удааширдаг байдал ихээхэн ажиглагддаг. Түүнчлэн улсын хөгжлийн төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй арга хэмжээ тусгаж байгаа нь хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрэхгүй байх, гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг урьдчилсан тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй нь жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд голлох сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийт 32 төсөл, арга хэмжээг 4,463.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэхээр баталсан бол 3,670.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 21 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, 429.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 10.0-50.0 хувьтай, 354.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээ 85.0 хувиас дээш буюу үр дүн гарсан байна. Энэ нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх төслүүдийн гүйцэтгэл

туйлын хангалтгүй байгааг харуулах бөгөөд энэ нь урьдчилсан судалгаа хийгээгүй, үндэслэлтэй төлөвлөөгүй, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээнүүдийг төлөвлөснөөс тус тус хамаарч байна.

2.2.Жилийн хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг сайжруулах талаарх зөвлөмж

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй гарч байгаа нь зөвхөн хэрэгжилтийн явцтай төдийгүй төлөвлөгөөг батлах, хянах зэрэг бусад хөгжлийн төлөвлөгөөний үе шатуудтай холбоотой гэж үзэж хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай холбоотой холбогдох зөвлөмжүүдийг хүргүүлж байна. Үүнд:

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай. Хөгжлийн төлөвлөлтийг батлах үйл явц, хэрэгжилтийн түвшинд хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцтэй байдлыг хангах, хөгжлийн бодлогын зорилтын тогтвортой байдлыг анхаарах

Хөгжлийн бодлогын үр дүн, үр нөлөөг тодорхойлох үзүүлэлт, хэмжүүрийг тодорхой болгох шаардлагатай. Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, түүний хэмжүүр нь нарийн тодорхой биш байгаагаас хөгжлийн тэргүүлэх чиглэл, дэд зорилтын хэрэгжилт хангагдсан байдлын үнэлгээ, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө тодорхой бус болж байгааг анхаарч цаашид сайжруулах.

Хөгжлийн бодлогууд уялдаатай байхаас гадна төсвийн бодлоготой нийцтэй байх хэрэгтэй. Хөгжлийн бодлого нь дунд, урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдаатай байдлыг сайжруулах. Төсвийн хязгаар, хүрэх үр дүнг хамтад нь төсвийн удирдамжийн хамт ТЕЗ нарт хүргүүлж, жилийн төлөвлөгөө ба төсвийн уялдааг хангаж, төрийн үйлчилгээг үр ашигтай, чанартай үзүүлж буй эсэхийг нь хянаж-шинжилж үнэлж, хариуцлага тооцдог байх нь хөгжлийн бодлогын үр дүнг нэмэгдүүлэх нөлөөтэйг анхаарах.

Хөгжлийн бодлогод тусгагдах хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ач холбогдол, нөлөөллийн хувьд эрэмбэлэх шаардлагатай. Жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгагдах хөтөлбөр, төсөл, арга хэмжээг бодлогын тэргүүлэх чиглэлд нийцтэй байдал ба эдийн засаг, нийгэмд үзүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, хэрэгжүүлэх байдлыг сайжруулах.

Хөгжлийн бодлогод тусгагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжилт хангагдах нөхцөлийг бүрдүүлэх. Санхүүжилтийн эх үүсвэрийн давхцалтай, санхүүжилт нь тодорхойгүй, шаардлагыг бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг дахин нягталж тухайн жилийн төлөвлөгөөнд тусгалгүй хасах, эсвэл хөрөнгийн тооцоог хийж, тусгасны дараа баталдаг болох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх. Жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилтийн дүнд багагүй хувийг эзэлдэг “бусад” гэсэн эх үүсвэрийг илүү тодорхой болгох, эсвэл тодорхойгүй төсөл, арга хэмжээг тусгахгүй байх. Мөн санхүүжилтээс гадна хэрэгжилтийг хангах, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд “сум, дүүргийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г боловсруулж хэрэгжүүлэх заалтыг нэмж оруулах

Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг сайжруулах. Төрөөс гадаад эдийн засгийн болон төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогыг илүү нарийвчилсан судалгаа, шинжилгээнд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх.

Цаашид Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөг хариуцлагатайгаар, үр дүнг нь хэмжиж болохуйцаар боловсруулж, хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг тайлагнаж, хянаж шинжилж, үнэлж хэвшихгүй бол улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, төр-хувийн

хэвшлийн түншлэлээр санхүүжүүлэх хөрөнгө үр дүнгүй, үр ашиггүй байдал үргэлжлэх нь тодорхой байна.

2.3.Хууль эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой санал

Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн төлөө 2025 онд улсын төсвийн 36, орон нутгийн төсвийн 722 ерөнхийлөн захирагч, 4,544 төсвийн шууд захирагч, 226,895 (2024 оны байдлаар) төрийн албан хаагч нийт 31.3 их наяд төгрөгийн төсөв зарцуулан хариуцлага хүлээн ажиллаж байгаа тул жилийн хөгжлийн төлөвлөгөө болон төсвийг боловсруулахдаа ямар үр дүнг, хэн хэрхэн хариуцаж ажиллахыг тодорхой болгох хэрэгтэй.

Иймээс цаашид хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад гардаг алдаа дутагдлыг засаж сайжруулахын тулд холбогдох хууль тогтоомжуудад тодорхой заалтыг нэмэх, нэмэлт өөрчлөлтийг тусгах шаардлагатай гэж үзэж байна.

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн тусгагдсан ХБТ-ийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн 21 дүгээр зүйлд “аливаа зорилт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хяналт шинжилгээ хийж байх” гэсэн утгатай 21.8 дахь заалтыг нэмж тусгах, Одоо мөрдөгдөж байгаа хуулийн дээрх заалт нь төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа, оны эцэст хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийнэ гэсэн заалт нь цаг хугацааны хувьд нэгэнт болж өнгөрсөн үйл явцад дүн шинжилгээ хийж байгаа тул ач холбогдол багатай, алдаа дутагдлыг цаг тухайд нь засахад тус нэмэр болохгүй байна.
2. Сангийн яамнаас боловсруулж байгаа “Улсын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийн төсөлд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх аливаа хөрөнгө оруулалтын төслийг эхлүүлэхийн өмнө бэлтгэл ажил бүрэн хангагдсан эсэхэд салбарын яамны зүгээс хяналт шалгалт тавьдаг байх, бэлтгэл ажил бүрэн хангагдсан гэж дээд шатны байгууллага, салбарын яамнаас үзсэн нөхцөлд Сангийн яамнаас уг төслийн урьдчилгаа хөрөнгийг шилжүүлдэг байх талаар зохицуулалтыг нэмж тусгах;
3. Барилгын тухай хууль, Автозамын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд төрийн захиргааны эрх бүхий байгууллагууд төслийг хэрэгжүүлэхэд хяналт тавих тухай заалт байгаа боловч автозам, барилга объект, эрчим хүчний шугам сүлжээ, барилга байгууламжийн барилга угсралтын ажлын явцад хяналт тавих тухай заалт байхгүй буюу учир дутагдалтай байна. Иймээс салбарын яамдын зүгээс өөрийн салбарт хэрэгжүүлж байгаа аливаа төсөл, хөтөлбөрийн бэлтгэл ажил хангагдсан эсэх, ажлыг гүйцэтгэх явцад явцын хяналт шалгалтын ажлыг зайлшгүй хийж, гарсан зөрчил дутагдлыг тухай бүрд нь залруулж, засуулж байх талаарх заалтыг нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна.
4. Бодит салбараас үйл ажиллагааны хувьд хол эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн салбарт салбарын яамны зүгээс улсын хөрөнгө оруулалтын ажлыг хариуцан ажиллаж байгаа нь ихээхэн учир дутагдалтай байна. Эдгээр салбарт барилга угсралтын ажлыг зөв зохион байгуулах, хяналт тавих мэргэжлийн инженер техникийн ажилтнууд, мэргэжлийн санхүүчид учир дутагдалтай байгаа тул цаашид эдгээр салбаруудад хэрэгжүүлэх барилга угсралт, хөрөнгө оруулалтын ажлыг мэргэжлийн өөр байгууллага хариуцдаг байх нь илүү оновчтой болно гэж үзэж байна.

Хавсралт 1.2024 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, хүрэх үр дүн

№	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
Тэргүүлэх чиглэлийн үр дүн										
1.	Экспортыг нэмэгдүүлнэ	Экспорт	Тэрбум ам.доллар	2022	12.5	13.7	ҮСХ	Салбарын тайлан	Жилд 1 удаа	ҮСХ
2.	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	Гадаадын хөрөнгө оруулалт	Тэрбум ам.доллар	2021	2.7	4	ЭЗХЯ	Статистик мэдээ	Жилд 1 удаа	ЭЗХЯ
3.	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна	Хүний хөгжлийн үзүүлэлт	Эрэмбэ	2021	96	92	ҮСХ	Статистик мэдээ	Жилд 1 удаа	ҮСХ
4.	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ	Хүлээн авах гадаад жуулчид	Тоо (сая)	2022	0.3	1.3	ҮСХ	Салбарын тайлан	Жилд 1 удаа	ҮСХ
5.	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна	Хүнсний аюулгүй байдлын индекс	Хувь	2021	53.5	57.6	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	Статистик мэдээ	Жилд 1 удаа	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
6.	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна	Хотын хөгжлийн үзүүлэлт	Оноо	2021	0.6	0.6	Нийслэлийн ЗДТГ	Статистик мэдээ	Жилд 1 удаа	Нийслэлийн ЗДТГ
7.	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж	Эрэмбэ	2021	108	100	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт	Экспертийн ярилцлага, тоон судалгаа	Жилд 1 удаа	ЗГХЭГ
8.	Ногоон хөгжлийг дэмжинэ	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	Эрэмбэ	2022	155	130	Иелийн их сургуулийн судалгаа	Холбогдох олон улсын аргачлал, тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ

Хавсралт 2.Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын тэргүүлэх чиглэлийн үнэлгээ

д/д	Бодлого	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувь
1	НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	1.Эдийн засгийн өсөлт	Хувь	2024	6	8	-	-
2	ХОЁР. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	1.Аймгуудын өрсөлдөх чадварын индексийн дундаж	Хувь	2023	66.5	70	-	-
		2.Хотын хөгжлийн индекс	Оноо	2021	0.5	0.6	0.5	45.6
3	ГУРАВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	1.Хүний хөгжлийн индекс	Эрэмбэ	2022	96	95	104	0
4	ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	1.Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж	Эрэмбэ	2022	113/180	112/180	111	100
		2.Авлигын индекс	Эрэмбэ	2023	121/170	118/170	114	100

Эх сурвалж: МУЗГ, 2026 он